



ГОЛОМТ БАНК

20

22
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2022

Агуулга

○ **БАНКНЫ ТУХАЙ**

Ерөнхий мэдээлэл

○ **ЗАСАГЛАЛ**

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн үйл ажиллагаа

Засаглалын үнэлгээний тайлан

Гүйцэтгэх удирдлага

Гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ дүгнэлт, мэдээлэл

○ **БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Макро эдийн засгийн төлөв байдал

Банкны салбарын үйл ажиллагаа

○ **БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ**

Банкны үйл ажиллагаа, онцлох үйл явдал

2022 оны ололт, амжилт

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Санхүүгийн үйл ажиллагаа

Аудитын дүгнэлт

Санхүүгийн тайлангууд

Санхүүгийн байдлын тайлан

Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлтүүд

Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ

Банкны нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив болон бусад үүрэг

○ **ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ**

○ **ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**

○ **НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ**

○ **ЦАЛИН УРАМШУУЛЛЫН МЭДЭЭЛЭЛ**

○ **НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА**




БАНКНЫ
ТУХАЙ

2022
тайлан

Монгол Улсын ууган арилжааны банкнуудын нэг Голомт банк нь 1995 онд үүсгэн байгуулагдаж 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2022 оны байдлаар 2,266 ажилтан, 1,040,426 харилцагчтайгаар үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Голомт банк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн түүхийн салшгүй нэг хэсэг нь байж, улсын хэмжээнд хөгжил дэвшил авчрах, эдийн засгийг солонгоруулахад хувь нэмэр оруулж буй хүсэл тэмүүлэлтэй, ёс зүйтэй, шилдэг бизнесүүдийг дэмжин санхүүжүүлсээр ирсэн билээ. Сайн сайхан ирээдүйг цогцлоохын төлөө үйлс бүхнээ зориулж буй Голомт банк улсын төсөвт нийт 646 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, 15 мянга гаруй ажлын байрыг бий болгоход шууд болон шууд бусаар дэмжлэг үзүүлжээ. Технологи суурьтай үйлчилгээгээр түүчээлэгч Голомт банк дэлхийн үсрэнгүй хөгжилтэй мөр зэрэгцэн дижитал шилжилтийн эхлэлийг тавьж, инновац шингэсэн дэвшилтэт шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг Монголын зах зээлд анхлан нэвтрүүлсээр ирсэн.

Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

Голомт Файнэншил Групп ХХК	Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаагаа явуулдаг 100% Монголын хөрөнгө оруулалттай компани юм.
Свисс-Мо Инвестмент Эй Жи	Тус хөрөнгө оруулалтын сангийн гол хувьцаа эзэмшигч нь Швейцари улсын иргэн, бизнесмен, филантропч Урс И.Шварценбах бөгөөд 2011 оны 6-р сараас эхлэн Голомт банкны хувьцаа эзэмшигч болсон.
Бодь Интернэшнл ХХК	Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт жуулчлалын салбаруудад үйл ажиллагаа явуулж байна.
Голомт Инвестмент Лимитэд	Голомт Инвестмент Лимитэд нь Монголын анхны томоохон групп компани болох Бодь Интернэшнл ХХК-ийн охин компани юм.
Олон нийт	Голомт банк хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг 2022 оны 11-р сард хийсэн. Голомт банкны IPO Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн том дүнтэй IPO болон хамгийн богино хугацаанд 114.4 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн гэх хоёр том амжилтыг бичиж үлдээсэн бөгөөд Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж байна.

Ерөнхий мэдээлэл

Тайлагнах хугацаа:	2022.01.01-2022.12.31
Нэр:	Голомт банк ХК
УБГД:	9016001014
РД:	2075377
Утас:	7011-1646
Факс:	+11-313155
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар:	Банк, санхүүгийн салбар
Аудитын компани:	ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК
Эргэлтэд гаргасан хувьцааны тоо:	808,657,306 ширхэг
Тайлан бэлтгэсэн ажилтан:	О.Номуншүр /Хөрөнгө оруулалтын менежер/

СЗХ, Үнэт цаасны бүртгэлийн журам, Маягт 1



ЗАСАГЛАЛ

2022 ТАЙЛАН

ЗАСАГЛАЛ

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь Хувьцаат компанийн шаардлагын дагуу нийт 9 гишүүнтэйгээр 3 гишүүн Хараат бус ТУЗ-ийн гишүүн ба жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон Швейцарын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөл зэрэг ТУЗ-ийн дийлэнх гишүүд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс ангид хараат бус гишүүд эзэлж байна.

Голомт банкны ТУЗ нь арилжааны болон хөрөнгө оруулалтын банкны салбарт олон жил ажилласан туршлагатай мэргэжлийн бүрэлдэхүүнтэй бөгөөд банк урт хугацаанд тогтвортой, ашигтай ажиллахад анхаарч банкны эрх ашгийг нэн тэргүүнд тавьж хариуцлагатай шийдвэр гаргах бүрэн чадамжтай болно.

Компанийн засаглал, засаглалын тогтолцоо

“Дэлхийн жишиг Монголын банк” алсын харааг Голомт банк 2018 онд батлан хэрэгжүүлснээр бүхий л үйл ажиллагаагаа, тэр дундаа ТУЗ-ийн хувьд Зохистой засаглалын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шилдэг туршлагыг нэвтрүүлж компанийн засаглал, засаглалын зохистой тогтолцоогоо төгөлдөржүүлэхэд анхаарал хандуулсаар ирсэн.

Энэхүү хүчин чармайлтын нэг үр дүн нь амжилттай нээлттэй хувьцаат компани болсон явдал юм. Хувьцаат компани болох нь засаглалын бүрдүүлсэн тогтолцоогоо олон нийтэд нээлттэй тайлагнаж, бүхий л үйл ажиллагаа нь ил тод болдгоороо онцлог юм. Бид ололт амжилт, ажлаа нээлттэй болгосноор банкны үйл ажиллагааг олон нийт улам сайн танин мэдэж, ойлгон, итгэлцэл бэхжих завшаан гэж үзэж байна.

Манлайлал

ТУЗ-ийн анхаарлаа хандуулдаг үндсэн чиглэл нь байгууллагын засаглалыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажилладаг соёлыг бий болгох юм. Гүйцэтгэх удирдлагатай хамтран ажиллаж, байгууллагын дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөг тогтвортой, ашигтай үйл ажиллагаа руу чиглүүлэн зөв зарчим, үнэ цэн, ёс зүйг баримталсан, байгууллагын эрх ашигт нийцсэн шийдвэр гаргалтыг дэмжихэд шаардлагатай дүрэм журмыг шинэчлэн ажиллаж байна.

Стратеги ба гүйцэтгэл


Тайлант хугацаанд Голомт банк нь 2022, 2023 оны стратеги төлөвлөгөөгөө нарийвчлан тодорхойлж албан ёсоор ТУЗ-өөр батлуулж ажиллалаа. Стратеги шинэчлэлийн хүрээнд Голомт банкны томоохон бодлогуудыг шинэчлэн сайжруулсан байна.

Тухайлбал:

- Актив пассивын удирдлагын бодлого
- Харилцагч төвтэй банкны бодлого
- Дотоод аудитын үйл ажиллагааны бодлого журмууд
- Бизнесийн процессын удирдлагын бодлого
- Хүний нөөцийн удирдлагын бодлого
- Мэдээллийн технологийн бодлого
- Комплаенсын бодлого
- Зээлийн бодлого
- Маркетингийн бодлого
- Тогтворжуулах бодлогын бичиг баримт

Бид стратеги төлөвлөлт хийх процессыг сайжруулаад зогсохгүй төсөв төлөвлөгөөний гүйцэтгэлийн хяналтыг сайжруулан ажиллаж байна. Төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээллүүдийг тогтмол ТУЗ-д тайлагнаж Дотоод аудитын газраар давхар баталгаажуулалт хийлгэдэг бөгөөд Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг тогтмол үнэлж, гэрээний үзүүлэлтүүдийг хувь хүн болон баг хамт олон, банкны нийт гүйцэтгэлтэй уялдуулан бие даан шийдвэр гаргах, багтай нийцэж ажиллах ажиллагааг тэнцвэртэй үнэлж дүгнэдэг болно.

БАНКНЫ ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО





МОНХОН

GOLOMT BANK

Moody's

Зээлжих зэрэглэлийн үнэлгээ
Төлөв
Эрсдэлийн үнэлгээ-Гадаад валют
Эрсдэлийн үнэлгээ-Дотоод валют
Зээлжих чадварын суурь үнэлгээ

B3
Stable
B3/NP
B2/NP
B3

S&P Global

Зээлжих зэрэглэлийн үнэлгээ
Төлөв
Үнэт цаасны үнэлгээ
Хөрвөх чадварын үнэлгээ

B/Stable/B
Stable
B
B+



ТУЗ-ИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

2022
ТАЙЛАН

ТУЗ-ийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн дарга
Ч.Мөнхцэцэг

Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн 3-р бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад мэргэжил дээшлүүлсэн. 1996 онд ажлын гараагаа Монголын хөрөнгийн биржээс эхэлж, Дэлхийн банк, Азийн сан зэрэг байгууллагад ажиллаж байсан. 2010 оноос “Тойм” сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан бөгөөд 2012 оны 12 дугаар сараас Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр сонгогдож, 2013 оны 12 дугаар сараас Голомт банкны ТУЗ-ийн даргаар томилогдон ажиллаж байна.



ТУЗ-ийн гишүүн
Урс Э.Шварценбах

Урс Э.Шварценбах нь Швейцар улсын Цюрих хотын Худалдааны коллежийг дүүргэж, 1968 онд Зюрих, 1972 онд Лондон дахь Юнион банканд ажиллаж байсан. 1976 оноос өөрийн бизнесийг эхлүүлсэн бөгөөд 2000 онд Канадын Нова Скотиагийн St. Francis Xavier University-ийн хүндэт доктор цолоор шагнуул. Ноён Урс.Э.Шварценбах нь 2010 оны 1 дүгээр сараас Швейцар улсад амьдарч байгаа ХБНГУын иргэдийг төлөөлөн Монгол Улсын Хүндэт консулаар өргөмжлөгдсөн. Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр 2011 оноос эхлэн ажиллаж байна.



**ТУЗ-ийн гишүүн
Ж.Үнэнбат**

Ж.Үнэнбат нь 1985 онд ОХУ-ын Москвагийн Эдийн засаг статистикийн дээд сургуулийг эдийн засагч, статистикч мэргэжлээр төгссөн. 1994 онд АНУ-ын Колумбын их сургуульд олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэг хамгаалсан, дэд профессор цолтой. 1990 оноос Монгол банканд ажиллаж эхэлсэн бөгөөд 1996–2000 онд Монгол банкны Ерөнхийлөгч, 2000–2006 онд Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал, 2009 оноос Компанийн засаглалын хөгжлийн төвийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж ирсэн. Мөнгөний бодлогын чиглэлээр судалгааны олон ажил хийсэн, банк санхүүгийн чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан нэгэн юм.



**ТУЗ-ийн гишүүн
Л.Болормаа**

Л.Болормаа, CFA нь МУИС-ийг Банк санхүүгийн чиглэлээр бакалавр, Virginia Polytechnic Institute and State их сургуулийг Олон улсын эдийн засагч, Япон улсын Олон улсын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. 1992 онд ажлын гараагаа Ардын банкнаас эхэлж, Герман улсын Deutsche Bank-ны АНУ-ын Нью-Йорк хот болон Японы Токио хот дахь салбаруудад хөрөнгө оруулалт, олон улсын зах зээл, эрсдэлийн удирдлага чиглэлээр ажиллаж байсан. 2015 оноос “Голомт фاینэншл групп” ХХК-д ажиллаж байсан ба банк санхүүгийн салбарт 20 гаруй жил ажилласан туршлагатай. 2020 оны 3 дугаар сараас Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаа ба мөн Голомт банкны “Жендерийн манлайлагч”-аар томилогдон ажиллаж байна.



**ТУЗ-ийн гишүүн
Д.Мөнхтөр**

Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн ЭЗС-ийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэг, 2009 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн. 1996 оноос Голомт банканд туслах ажилтнаас эхлэн эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, Тэргүүн дэд захирлын үүрэгт ажлыг хашиж байсан бөгөөд 2012 оноос ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.



**ТУЗ-ийн гишүүн
О.Ганжолоо**

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт Их Сургуулийг эдийн засгийн онолын чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн. Мөн Их Британийн Нэгдсэн Вант Улс болон Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй. Тэрбээр ХБНГУ болон Монгол дахь Олон улсын PwC аудитын компанийн салбаруудад ажиллаж байсан ба өмнө нь “Бодь интернэшнл” ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байсан туршлагатай. О.Ганжолоо нь 2016 оноос “Голомт фاینэншил групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа бөгөөд 2022 оноос эхлэн Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.



**ТУЗ-ийн хараат бус гишүүн
Жэймс Б.Двайер**

Жэймс Б.Двайер нь Нотр Дам их сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн ба мэргэшсэн санхүүгийн шинжээч юм. Тэрбээр 1970 оноос хойш UBS банкны Компанийн нэгдэл, компани худалдан авах процесс хариуцсан захирал зэрэг Нью-Йоркийн Wall - street-д байрлалтай санхүүгийн байгууллагад хөрөнгө оруулалтын банкир хийж байсан туршлагатай. Ноён Двайер 2001 онд Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны хувьчлалын ажиллагаанд оролцохоор Монгол Улсад анх хөл тавьж, Хойд Америкийн бизнес зөвлөлд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2007 онд Монголын бизнесийн зөвлөлийг үүсгэн байгуулсан. Тэрбээр “Мандал даатгал” болон “Mongolia Growth Group” ХХК-иудад ТУЗ-ийн хараат бус гишүүн, Mongoljin private capital-ийн Гүйцэтгэх бус ТУЗ-ийн дэд дарга, Монголын боловсролын сангийн ТУЗ-ийн дарга, Ерөнхийлөгчийн албыг хашдаг.



**ТУЗ-ийн хараат бус гишүүн
Антонио Л.Абеллос**

Антонио Л.Абелло нь Испанийн Барселоны их сургуулийг хуульч мэргэжлээр, IESE бизнесийн сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. Барселоны хуулийн холбооны мэргэшсэн хуульч, CEFFAS стандартын дагуу Мэргэшсэн санхүүгийн аналит зэрэгтэй. Кредит свисс, Голдмэн сакс болон Парибас банканд бонд болон хөрөнгийн санхүүжилт хариуцсан удирдах түвшний албан тушаалуудыг хашиж байсан. Сингапур болон Лондон хотын хөрөнгө оруулалтын тэргүүлэгч банкуудад 20 гаруй жил ажилласан, олон улсад өндрөөр үнэлэгддэг туршлагатай банкируудын нэг юм. Тэрбээр Turms Advisors LLP фирмийг үүсгэн байгуулагч, партнераар ажилладаг. 2014 онд Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон.



**ТУЗ-ийн хараат бус гишүүн
Александр Пикер**

Александр Пикер нь Австри улсын Салзбургийн их сургуулийг бизнес, хуулийн чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн. Анх 1989 онд ажлын гараагаа одоогийн Австри банкнаас эхлүүлж, Die ERSTE bank, Inter - national Moscow Bank (IMB), Uni - credit Bank, JSC ATF Bank Hypo Alpe-Adria Bank, HBI Bundesh - olding AG зэрэг банканд эрсдэл хариуцсан захирал, үйл ажиллагаа хариуцсан захирал, гүйцэтгэх захирал зэрэг удирдлагын албан тушаалдаажиллаж байсан олон жилийн туршлагатай. Тэрбээр одоо Дэлхийн банкны томоохон төслүүдэд ахлах зөвлөх, Узбекистаны Ипотека банкны хяналтын зөвлөлийн даргын албан тушаалыг хашиж байгаа бөгөөд 2021 оноос Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



**ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
З.Солонго**

З.Солонго нь 2003 онд Энэтхэг улсын Гужарат мужийн Сардар Пател их сургуульд бакалаврын зэрэг, 2017 онд СЭЗИС-д Компанийн засаглалаар мэргэшсэн Бизнес удирдлагын магистр зэрэг хамгаалсан. 2017 онд Олон улсын санхүүгийн корпорацаас (IFC) Сингапур улсад зохион байгуулсан Ази бүсийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын магистрын хөтөлбөрт хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн. 2007 оноос Голомт банканд ажиллахдаа Гүйцэтгэх захирлын түвшинд Нарийн бичгийн дарга, Туслах, ТУЗ-ийн Хорооны нарийн бичгийн даргын албан тушаал хашиж, 2015 оноос хойш Голомт банкны ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар ажиллаж байна.



**Аудит хариуцсан захирал
А.Одонбаатар**

А.Одонбаатар нь 2008 онд МУИС-ийн ЭЭС-ийн Банкны менежментийн бакалаврын зэрэг, 2013 онд Энэтхэг улсын Bangalore их сургуулийн Санхүүгийн удирдлага, Маркетингийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. 2008-2014 онд Голомт банкны Дотоод аудитын газарт аудитор, 2014-2015 онд Зайсан Скүэр тооцооны төвийн захирал, 2015-2016 онд Дотоод аудитын газрын Мэдээллийн технологи, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн захирлаар тус тус ажиллаж байсан. 2016 оноос Голомт банкны Аудит хариуцсан захирлаар ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Эрсдэлийн Удирдлагын Хороо

Голомт банкны Эрсдэлийн удирдлагын хороо нь ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр даргалуулдаг, ТУЗ-ийн 3 хараат бус гишүүн болон ердийн 2 гишүүнээс бүрддэг ба сард дунджаар 2 удаа хуралдаж банкны нийт эрсдэлийг зохистой байдлаар тодорхойлж, эрсдэлийн хүлээн зөвшөөрч болох хэм хэмжээг тогтоон, хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаардаг.

Тус хороо нь банкны нийт эрсдэл буюу санхүүгийн ба санхүүгийн бус эрсдэл, зээл, үйл ажиллагааны болон комплаенсийн эрсдэлүүдийг удирдах асуудлыг банкны бодлогын хэмжээнд хангаж ажиллах, хэрэгжилтийг хянах гол чиг үүрэгтэй. Тус хорооны дүрэмд тусгагдаж, бүтцээр хангагдсанаар Эрсдэл хариуцсан захирал нь тус хороонд тайлагнах журамтай болно. Тиймээс Эрсдэл хариуцсан захирлын гол анхаарч ажиллах асуудал болон жилийн төлөвлөгөөтэй танилцаж үүрэг зөвлөмжөөр хангаж ажилладаг. Мөн Эрсдэлийн удирдлагын хороо нь зээлийн эрсдэлийг чухалчлан авч хэлэлцдэг бөгөөд 20 тэрбум төгрөг буюу түүнээс дээш зээл болон түүнтэй адилтгах активын үүрэг хүлээсэн групп компаниудын зээлийг хэлэлцэн баталдаг. Түүнчлэн Гүйцэтгэх захирлын удирддаг Зээлийн хорооны шийдвэрийг хянаж үзээд хэт эрсдэлтэй бол тус шийдвэрийг хэрэгжүүлэхэд “Хориг тавих” эрхтэй ажиллаж банкны бүхий л томоохон эрсдэлүүдэд анхаарч, удирдан чиглэл өгч ажилладаг болно.

ЭУХ-ны зөвлөмжийн дагуу ТУЗ нь дараах гол бичиг баримтуудыг батлан Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэх чиг үүрэг өгч хянадаг болно.

1. Risk Appetite Framework/Risk Appetite Statement Эрсдэлийн аппетитын бодлого бичиг баримт
2. Эрсдэлийн лимитүүд
3. Зээлийн бодлого
4. Зээлийн хорооны дүрэм
5. Комплаенсийн бодлого
6. Засаглалын кодекс дахь бодлогын бичиг баримтууд. Үүнд:
 - Ёс зүйн дүрэм
 - Авлигын эсрэг бодлого
 - Сонирхлын зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх журам
 - Мэдээллийн тэнцвэртэй байдлын бодлого
 - Луйврын эсрэг бодлого
 - Улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого
 - Зөрчлийг мэдээлэх тухай бодлого – шүгэл үлээх

Эрсдэлийн удирдлагын хорооны тогтмол авдаг тайлангууд:

1. Эрсдэлийн тайлан:

Санхүүгийн эрсдэл:

- Зах зээлийн эрсдэл
- Зээлийн эрсдэл
- Зээлийн багцын мэдээлэл – сар бүрээр

Санхүүгийн бус эрсдэл:

- Үйл ажиллагааны эрсдэлийн тайлан
- Комплаенсийн эрсдэлийн тайлан
- МУТСТэмцэх үйл ажиллагааны тайлан

2. Гүйцэтгэх удирдлагын түвшний Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан

3. Зээлийн хорооны шийдвэрийг хянах

4. Эрсдэлийн бодлогын хэрэгжилт – RAF/RAS эрсдэлийн метриксүүдийн хэрэгжилт

Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо

Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо нь Голомт банкны Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогуудын хэрэгжилтийн асуудлыг хамаардаг. Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгч ажилладаг болно. Хороо нь ТУЗ-ийн гишүүд, банкны гүйцэтгэх удирдлагатай холбоотой шалгаруулалт, цалин, урамшууллыг зөв зохистой тодорхойлж, тэдний ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнэх, ТУЗ-д санал болгох, зөвлөх үүрэгтэй.

Тус хороо нь улиралд нэг удаа хуралдах ээлжит хурлын товтой энэ нь жилийн эхэнд батлагдаж төлөвлөгддөг. Үүнээс гадна хэлэлцэх асуудлаас хамаараад тухай бүр ээлжит бус хурал зарлан хуралдуулдаг.

Тайлант хугацаанд Засаглалын хороо нь Гүйцэтгэх удирдлагын (ГУ) багийн ажлын гүйцэтгэлийг Гүйцэтгэх захиралтай хамтран хийж, гэрээний гүйцэтгэлийг хэмжих гол нөхцөлүүдийг шинэчлэн сайжруулж ажилласан ба ингэснээр ГУ-ын томилгоо, хариуцлага, гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын тогтолцоог цогц хэлбэрээр бүрдүүлэн ажиллалаа.

Банкны үйл ажиллагаа хөгжиж, бизнесийн цар хүрээ тэлж, зах зээлийн орчин өөрчлөгдөх тусам банкны бүтэц зохион байгуулалт даган сайжирч байдаг. Засаглалын хороо нь банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх асуудлыг дэлгэрэнгүй хэлэлцэж, хариуцдаг бөгөөд Хорооны зөвлөмжийн дагуу ТУЗ-өөс хэлэлцүүлэн батлуулдаг болно.

Тус хорооны зөвлөмжийн дагуу ТУЗ-өөс баталсан бодлогын бичиг баримтууд нь:

1. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт
2. Хүний нөөцийн бодлого
3. Цалин, урамшууллын бодлого

Түүнээс гадна банкны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой дүрэм, журамтай танилцан, хянан хэлэлцэж зөвлөмжөө өгч ажилладаг. Тиймээс банкны борлуулалт болон төвийн нэгжийн цалингийн систем, тэдгээрийн гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем, сонгон шалгаруулах журам, ажилтанд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох журам, ажилтнуудын халамж тэтгэмжийн журам зэрэг холбоотой бичиг баримтуудтай танилцаж санал өгдөг. Мөн хүний нөөцтэй холбоотой дараах явцын тайлангуудтай танилцдаг болно. Үүнд:

- Дараа жилийн Хүний нөөцийн төлөвлөгөө, цалин урамшууллын зардлыг энэхүү хороогоор урьдчилан хэлэлцэж саналаа өгсний дараа нэгдсэн банкны төсөв, төлөвлөгөөнд тусгадаг болно.
- Хүний нөөц хариуцсан захирлаас хүний нөөцтэй холбоотой гол анхаарал асуудлууд, хийх ажлын төлөвлөгөөг мөн авч танилцдаг.
- Хүний нөөцийн хөдөлгөөн шилжилтийн анализ хийж ирээдүйн төлөвлөгөө, соёлын арга хэмжээнүүдийг авч ажилладаг.

Тус хороо нь тайлант хугацаанд нийт 5 удаа хуралдаж 15 асуудал хэлэлцсэн байна.

Аудитын хороо

Голомт банкны дотоод аудитын үйл ажиллагаа нь Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо, Аудит хариуцсан захирал, түүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Дотоод аудитын газар, Дата анализын алба гэсэн бүтэцтэй зохион байгуулагдсан байдаг. Дотоод аудитын газар нь Ерөнхий аудитын хэлтэс, Мэдээллийн технологийн аудитын хэлтэс, Зайны аудит, чанарын баталгаажуулалтын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр чиг үүргээ хэрэгжүүлдэг.

Голомт банк нь дотоод аудитын үйл ажиллагаандаа нэр хүнд бүхий Олон улсын байгууллагаар Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэж, Олон улсын Дотоод аудиторчуудын институт (The Institute of Internal Auditors)-ийн Дотоод аудитын мэргэжлийн туршлагын Олон улсын стандарт /IPPF-ыг бүрэн хангаж байна гэдэг үнэлгээ авсан Монгол Улсын цор ганц байгууллага юм.

Мөн “Бизнесийн уялдаа, Эрсдэлд төвлөрсөн байдал”, “Талентын загвар”, “Чанар ба Инновац”, “Технологи”, “Оролцогч талуудын удирдлага ба Үйлчилгээний соёл” гэсэн 5 үзүүлэлтээр үнэлэгдэж, Дотоод аудитын хөгжлийн 6 түвшингийн 5 дахь түвшин буюу “Insight generator” түвшинд байна гэж үнэлэгдсэнээс гадна бүс нутгийн 500 орчим Дотоод аудитын нэгжтэй харьцуулахад “Голомт банкны Дотоод аудитын үйл ажиллагаа нь бүх үзүүлэлтээр манлайлж байна” гэж дүгнэгдсэн.

Дотоод аудитын үйл ажиллагаа нь Гүйцэтгэх удирдлага болон бусад нэгж, үйл ажиллагаанаас хараат бус байдаг ба Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудит хариуцсан захирлыг томилох, Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэм, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, стратеги болон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө, зардлын төсвийг баталдаг. Аудитын тайланг сар бүр, аудитын төлөвлөгөөний биелэлт, зөвлөмжийн биелэлт зэрэг үйл ажиллагааны тайланг улирал бүр ТУЗ, Аудитын хороонд тайлагнадаг.

Дотоод аудитын үйл ажиллагаа 2022 онд:

2022 онд Дотоод аудитын үйл ажиллагаа нь бүтцийн өөрчлөлт хийж, Мэдээллийн технологийн аудит, дата анализын хэлтсийн харьяанд үйл ажиллагаагаа явуулж байсан Дата анализын албыг Дотоод аудитын газрын бүтцээс гаргаж, Аудит хариуцсан захирлын харьяанд, хараат бусаар шинэчлэн байгуулсан. Тус алба нь дотоод аудитын үйл ажиллагааг дата анализын “predictive analysis” түвшний тусламжтай оновчлох, процессын робот автоматжуулалт нэвтрүүлэх зорилготой.

Аудитын үйл ажиллагааг дэмжих чиглэлд хөгжүүлэгдсэн өгөгдөл боловсруулалт, дашбоард гэх мэт дата бүтээгдэхүүнүүд нь аудитын үйл ажиллагааны өөрчлөлт, шинэчлэлтэй нийцэн тасралтгүй сайжирч, шинэчлэгдэж байгаа бөгөөд 2022 онд Банкны бизнес төлөвлөгөөний үзүүлэлтүүд, Зайны аудит, Сэжигтэй гүйлгээний анализыг автоматжуулах чиглэлд онцгой дэвшил гаргалаа.

2022 онд Дотоод аудитын үйл ажиллагаа нь дотоод чанарын баталгаажуулалт хийдэг, Чанарын баталгаажуулалт, сайжруулах хөтөлбөрт байнгын хяналт хийж, дүгнэлт өгдөг, үйл ажиллагааг сайжруулах, олон улсын сайн туршлагатай нийцүүлэх чиг үүрэгтэй бүтцийг бий болгон ажиллуулж байна.

Дотоод аудитын газар нь 2022 онд аудит хийхдээ сайн засаглалын бүх зарчмуудад онцгой анхаарал хандуулахаас гадна шинээр бий болж буй эрсдэлд төвлөрч ажиллалаа. Мөн банкнаас өөр байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлж, мэдлэг ур чадвараа хуваалцлаа.

Дотоод аудиторууд мэргэжлийн ур чадвараа дараагийн түвшинд гаргаж, Олон улсын мэргэшсэн байгууллагаас олгодог Мэдээллийн системийн мэргэшсэн аудитор /Certified Information Systems Auditor® (CISA®)/, Скрам мастер /Scrum master/ цолуудыг авснаас гадна Монгол улсын мэргэшсэн институтээс олгодог Мэргэшсэн нягтлан бодогчийн цолыг авсаар байна.

Аудит хариуцсан захирал нь 2022 онд Олон улсын Дотоод аудиторуудын институт (IIA)-ийн Монгол дахь албан ёсны салбар болох Монголын үндэсний дотоод аудиторуудын холбоо (IIA Mongolia chapter)-ны Залгамж халааны бодлогын дагуу Удирдах зөвлөлийн дарга А.Одонбаатар нь ажлаа өгч, Удирдах зөвлөлийн дарга асан статуст шилжин, Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Мөн Аудит хариуцсан захирал А.Одонбаатар нь Монголын Банкны Холбооны Аудитын хорооны дарга, Дотоод аудитын мэргэжлийн зөвлөлийн гишүүний сонгуульд тус тус ажиллалаа.


Аудитын хорооны үйл ажиллагаа

Голомт банкны Аудитын хороо нь 2022 онд 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Жеймс Б.Двайер ажиллаж байна. Аудитын хороо нь дараах үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг.

- Санхүүгийн тайлантай холбоотой
- Дотоод хяналтын тогтолцоотой холбоотой
- Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Компаенсын үйл ажиллагаатай холбоотой
- Тайлагналын үйл ажиллагаатай холбоотой
- Бусад үйл ажиллагаатай холбоотой

2022 онд хэлэлцсэн асуудлууд:

Аудитын хороо нь 2022 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 9 удаа, дунджаар 93%-ийг ирцтэйгээр хуралдан, 52 асуудлыг хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.



Хэлэлцсэн асуудлууд

- Дотоод аудитын тайланг тайлагнахтай холбоотой
- Банкны бодлого, стратеги, бизнес төлөвлөгөө, бусад төлөвлөгөөг танилцуулах, батлуулахтай холбоотой
- Банкны бизнес төлөвлөгөө, нэгжийн гүйцэтгэлтэй холбоотой /санхүүгийн үр дүн, төсөл, бусад төлөвлөгөө гм/
- Дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тайлагнах, төлөвлөгөөг батлуулахтай холбоотой
- Бусад
- Хөндлөнгийн аудиттай холбоотой
- Монголбанкны шалгалттай холбоотой

Аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, банкны нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй байна. Дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын тайлан, илэрсэн зөрчил, зөвлөмжүүд нь Аудитын хороонд шууд тайлагнагддаг.

Тус хороо нь сар бүрийн санхүүгийн үзүүлэлтүүдийг хянаж, Удирдлагын багт үүрэг, зөвлөмж өгдөг. Мөн хөндлөнгийн аудитын тайланг хэлэлцэж, батлах саналыг ТУЗ-д хүргүүлэн ажилладаг болно.

Аудитын хороо нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, хууль эрх зүйн орчинд гарч буй санхүүгийн тайлагналд нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтүүдийн талаар байнгын мэдээлэлтэй байдаг. Мөн Дотоод аудитын газрын эрх, үүргийг тусгасан дүрэм, үйл ажиллагааны журам, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлдэг. Мөн Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг, үйл ажиллагаандаа олон улсын стандарт, арга аргачлалыг ашиглаж буй эсэхийг болон аудитын тайлан, тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянадаг. Аудитын хороо нь Аудит хариуцсан захирлыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-д хүргүүлж, ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин урамшууллыг тогтоодог.

ТУЗ-ийн үйл ажиллагаа

2022 онд Голомт банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нийт 12 удаа ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулж, нийт 61 асуудлыг хэлэлцэн зөвлөлдөж, 34 тогтоол, шийдвэрийг батлав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан тогтоол, шийдвэрүүд:

1. Стратеги, хөрөнгө оруулалттай холбоотой

-Нийт ТУЗ-ийн хурал, Хороодын хурлаар 20 гаруй хэлэлцүүлэг болсны үндсэн дээр нийт 9 холбоотой шийдвэр гаргасан байна. 2022 онд баримтлах стратеги, бизнес төлөвлөгөө, төсөв зэрэг асуудлууд хамарсан байна.

2. Дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт сайжруулахад чиглэсэн

-Нийт 17 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

3. Бодлогын баримт бичиг, дүрэм журам, засаглалыг сайжруулахад чиглэсэн

-Нийт 10 бодлого журмыг сайжруулан шинэчилсэн байна.



ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

Монголбанкны ерөнхийлөгчийн 2014 оны 09 сарын 30-ны өдрийн А-151 тоот тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын нэгдүгээр хавсралт болох “Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар”-ийн дагуу Голомт банк нь зохистой засаглалын зарчмуудын хэрэгжилт тайланг жил бүрийн 04 сарын 30-ны дотор журмын дагуу илгээж үнэлгээг хийлгэдэг.

Тайлант хугацаанд 2022 оны 04 сард тайланг Монголбанкинд хүргүүлсэн ба зохицуулагчаас хянан үзээд Голомт банкны үнэлгээг сайн буюу “Удирдлагын үйл ажиллагаа нь хэвийн банк” гэж үнэлсэн байна.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН АЖЛЫН ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭН ТУЗ ДҮГНЭЛТ, МЭДЭЭЛЭЛ



“Голомт банкны 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, хөндлөнгийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс хянан үзээд “Голомт банк нь 2022 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” хэмээн дүгнэсэн болно.”



ГҮЙЦЭТГЭХ
УДИРДЛАГА

2022
ТАЙЛАН

Гүйцэтгэх удирдлага



Норихико Като
Гүйцэтгэх захирал



Г.Ганболд
Ерөнхийлөгч



Т.Нямсүрэн
Гүйцэтгэх захирлын
орлогч бөгөөд Эрсдэл
хариуцсан захирал



Д.Бадрал
Гүйцэтгэх захирлын
орлогч бөгөөд Бизнес
хариуцсан захирал



М.Сайнбилэг
Мэдээллийн технологи
хариуцсан захирал



С.Мөнхтуяа
Санхүү удирдлагын
газрын захирал



М.Наранхүү
Зээлийн газрын
захирал



Т.Отгон
Эрсдэлийн удирдлагын
газрын захирал



Б.Содболор
Нөөцийн удирдлагын
газрын захирал



Ц.Байгалмаа
Иргэдийн банкны
газрын захирал



З.Мягмардорж
Байгууллагын банкны
газрын захирал



Г.Уянга
Хүний нөөцийн
удирдлагын газрын
захирал



Н.Очирхуяг
Маркетинг, олон
нийттэй харилцах
газрын захирал



Ё.Пүрэвбат
Бүртгэл тооцооны
газрын захирал



Х.Пүрэвдорж
Захиргааны газрын
захирал



О.Батцэнгэл
Мэдээлэл технологийн
газрын захирал



А.Нямсүрэн
Бизнес процесс
менежментийн газрын
захирал



БИЗНЕСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

2022 ТАЙЛАН


Макро эдийн засгийн төлөв байдал

Мөнгөний хатуу бодлогын үр дүнд банкны салбарын нийт зээл ба хадгаламжийн өсөлт буурав.

2019 оны сүүлчээс эхэлсэн цар тахлын нөлөө намжиж амжаагүй байхад 2022 оны эхээс эхэлсэн гэнэтийн дайны нөлөөгөөр эдийн засгийн хувьд болон бодлого боловсруулагчдын хувьд хүндхэн жил болж өнгөрлөө. Орос Украины дайнаас шалтгаалан олон улсад тэр дундаа АНУ болон Европын улсуудад шатахууны хомсдолоос үүдэж инфляц өмнөх 40 жилд тохиолдож байгаагүй өндөр түвшинд хүрсэн. Улс орнуудад инфляц өссөнөөр эцсийн бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж манай улсын эдийн засагт ч мөн импортын бараагаар дамжин нөлөөллөө үзүүллээ. Нэг талаас геополитикийн асуудал, нөгөө талаас “Тэг Ковид” бодлогоос үүдэлтэй хилийн хориг саад, тээвэр логистикийн асуудал инфляцыг 2022 оны турш ойролцоогоор 15 хувьтай хадгалагдахад нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт болон бодлогын хүү:


Бодлогын хүү өсөх нь мөнгөний нийлүүлэлт буурахад нөлөөлж байна.



Монгол Банкнаас инфляцыг бууруулах болон төгрөгийн үнэ цэнийг хадгалах зорилгоор бодлогын хүүг удаа дараа өсгөж оны эцсээр 13 хувьд хүргэлээ. Бодлогын нөлөөгөөр цар тахал гарснаас хойш оргил үедээ 32 хувийн өсөлттэй байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч оны эцэст 6.5 хувьтай гарлаа.

Ханш болон харилцах, хадгаламжийн дүн:


Иргэдийн төгрөгт итгэх итгэл буурснаар долларжих үзэгдэл явагдаж байна.



2022 он гарснаас хойш төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч байгаа нь Монголбанк дахь гадаад валютын албан нөөцийн хэмжээг буулгаж ханшид сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн 2022 он гарснаас хойш төгрөгийн доллартай харьцах ханш 21 хувиар буурсан нь иргэдийн төгрөгт итгэх итгэлийг бууруулав. Үүний нөлөөгөөр банкны системд долларжих үзэгдэл явагджээ. Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ өмнө жилтэй харьцуулахад 6.5 хувийн өсөлттэй байсан ч үүнд голлон валютын харилцах, валютын хадгаламжийн өсөлт нөлөөлсөн. Тодруулбал, жилийн өөрчлөлтийн 9.3 нэгж хувийг гадаад валютын харилцах, 3.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 2.5 нэгж хувийг төгрөгийн харилцах, -0.1 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -8.7 нэгж хувийг төгрөгийн хадгаламжийн өөрчлөлт тус тус тайлбарлаж байна. 2022 оны эцэст өмнө жилтэй харьцуулахад валютын харилцах 111 хувиар, валютын хадгаламж 20.2 хувиар өссөн бол төгрөгийн хадгаламж 15.4 хувиар буурсан үзүүлэлттэй байлаа. Инфляцын түвшин өндөр байсан нь төгрөгийн бодит хадгаламжийн хүүг буулгаж иргэдийн дунд хадгалахаас илүү хэрэглэх сонирхол өндөр болоход нөлөөлжээ.

Өрхийн орлого, зарлага:

Өрхийн орлого, зарлагын өсөлт




Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу 2022 онд “Ипотекийн зээл”-ийн төлөлтийг үргэлжлүүлэн царцаасан нь өрхийн зардлыг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Гэсэн хэдий ч нийт зээл олголт багасаж, зээлийн хүүгийн төлбөр өссөн, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ хөөрөгдсөн зэрэг нь өрхийн зарлага нэмэгдэх шалтгаан болжээ. Цар тахал гарснаас хойш оргил үедээ 23 хувийн өсөлттэй байсан өрхийн орлого 2022 оны 3-р улирлын байдлаар 11.7 хувь болж буурсан харин зарлагын хувьд 2021 он гарснаас хойш 25.3 хувьд хүрч өссөн хэдий ч инфляцын нөлөөллийг нь тооцоолж үзвэл бодит өрхийн орлого 2.4 хувиар буурч, бодит өрхийн зарлага 8.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Банкны салбарын үйл ажиллагаа

Банкны салбарын гүйцэтгэл:

Үзүүлэлтүүд	Нэгж	2020	2021	2022	2022 оны өсөлт
Нийт актив	тэрбум ₮	36,685	41,012	46,003	12.2%
Нийт зээлийн үлдэгдэл	тэрбум ₮	17,476	21,205	22,205	4.7%
Хугацаа хэтэрсэн зээл	тэрбум ₮	1,265	932	1,123	20.5%
Чанаргүй зээл	тэрбум ₮	2,002	2,073	2,019	-2.6%
Чанаргүй зээлийн харьцаа	%	11.5%	9.8%	9.1%	-7.0%
Иргэдийн зээл, ₮	тэрбум ₮	8,463	10,328	11,492	11.3%
Иргэдийн зээл, \$	тэрбум ₮	68	63	63	0.0%
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	250	177	269	52.1%
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, \$	тэрбум ₮	1	4	1	-81.0%
Чанаргүй зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	471	472	479	1.5%
Чанаргүй зээл, Иргэд, \$	тэрбум ₮	26	22	22	-0.3%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, ₮	%	5.6%	4.6%	4.2%	-8.8%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, \$	%	37.6%	34.9%	34.8%	-0.4%
Байгууллагын зээл, ₮	тэрбум ₮	6,488	8,580	8,980	4.7%
Байгууллагын зээл, \$	тэрбум ₮	1,440	1,235	1,156	-6.4%
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	684	449	690	53.8%
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	320	299	163	-45.4%
Чанаргүй зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	1,271	1,425	1,358	-4.7%
Чанаргүй зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	222	146	151	3.5%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, ₮	%	19.6%	16.6%	15.1%	-9.0%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, \$	%	15.4%	11.8%	13.1%	10.6%
Нийт харилцах хадгаламж	тэрбум ₮	23,350	26,965	28,758	6.6%
Харилцах данс, ₮	тэрбум ₮	3,513	5,854	6,693	14.3%
Харилцах данс, \$	тэрбум ₮	1,983	2,345	4,947	111.0%
Хадгаламж, ₮	тэрбум ₮	13,314	14,963	12,657	-15.4%
Хадгаламж, \$	тэрбум ₮	4,609	3,904	4,694	20.2%
Өөрийн хөрөнгө	тэрбум ₮	3,059	3,425	4,454	30.0%
Нийт пассив	тэрбум ₮	33,627	37,586	41,549	10.5%

Зээлийн хүү болон банкны харилцах хадгаламж, зээлийн өсөлт



Бодлогын хүүгийн нөлөөгөөр хадгаламж, зээлийн хүү өсөж 2022 оны эцсээр хадгаламжийн хүү 10.9 хувьд, зээлийн хүү 15.7 хувьд хүрчээ. Ийнхүү цар тахал гарснаас хойш оргил үедээ 23 хувийн өсөлттэй байсан харилцах, хадгаламжийн хэмжээ 2022 оны эцэст 6.5 хувиар өссөн байна. Зээлийн хэмжээ оргил үедээ 29.1 хувьд хүрч байсан бол оны эцэст 4.7 хувь болж өсөлтийн хувь саарсан. Нийт харилцах, хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 2022 оны эцэст 30.7 их наяд хүрч өмнө жилтэй харьцуулахад 1.9 их наяд буюу 6.5 хувиар өссөн нь зарим эдийн засагчдын үзэж буйгаар түр хугацааны шок юм. Банкны салбарын эх үүсвэр 2022 оны эхний 11 сарын турш өсөлт үзүүлээгүй ба нэг сарын дотор 2 их наяд орчим төгрөгөөр өссөн нь шокийн шинж чанарыг харуулж байна. Харин зээлийн үлдэгдлийн хувьд 22.2 их наяд хүрсэн бөгөөд өмнө жилтэй харьцуулахад 1 их наяд буюу 4.7 хувиар өсжээ.



**Great
Place
To
Work®**

Certified

11.2022-11.2023
MONGOLIA

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Great place to work institute"-ээс
Голомт банкийг "Ажиллахад хамгийн таатай газар"-аар батламжиллаа.



БАНКНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА,
ОНЦЛОГ


2022 ТАЙЛАН

Банкны үйл ажиллагаа, онцлох үйл явдал

Харилцагч төвтэй Голомт банк нь орон даяарх 1 сая гаруй харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй хөгжүүлж, ойлгомжтой, хүртээмжтэй, түргэн шуурхай үйлчилгээг нийт 102 салбар, тооцооны төв, хадгаламжийн кассаар дамжуулан хүргэж байна.

Голомт банк хувьцаагаа олон нийтэд гаргаж, нээлттэй хувьцаат компани боллоо

Голомт банк хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг 2022 оны 11-р сард хийсэн. Голомт банкны IPO Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн том дүнтэй IPO болон хамгийн богино хугацаанд 114.4 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн гэх хоёр том амжилтыг бичиж үлдээсэн.



Анхдагч зах зээлийн арилжааны үед олон нийтээс ирсэн захиалгын эрэлт өндөр байсан тул Голомт банк болон андеррайтерийн зүгээс үнэт цаасны танилцуулгын 5.7-д заасны дагуу Greenshoe хэрэгжүүлж, хувьцааны 15%-тай тэнцэх хэмжээний буюу 12,060,411 ширхэг хувьцааг нэмэлтээр гаргахаар шийдвэрлэсэн. Ингэснээр нийт 92,463,154 ширхэг хувьцаа гаргаж нийт 118,815,152,890 төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.

2023 оны 01 сард Хөрөнгийн биржийн Top 20 индекс шинэчлэгдэж Голомт банк ХК тус багцад багтсан бөгөөд Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдаж байна.

Картын шинэ систем нэвтрүүлээ

Голомт банк Нээлттэй Банк" стратегийн хүрээнд картын бизнес бүтээгдэхүүн үйлчилгээ, технологийн хөгжлийг дэмжсэн, олон улсын стандартад бүрэн нийцсэн картын шинэ системийг CARDZONE байгууллагатай хамтран нэвтрүүлээ. CARDZONE нь 2008 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа Малайз улсад төвтэй, олон улсад картын систем нийлүүлэгч байгууллага юм.

Энэхүү систем нь төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCIDSS стандартад нийцсэн, интернет худалдааны 3DS хамгаалалтын V2.0 хувилбарыг хэрэгжүүлсэн, банкны



бусад системүүдтэй холболт хийхэд шаардлагатай бүх сервисийг багтаасан төдийгүй банкны картын үндсэн системд байх технологийн шаардлагуудыг бүрэн хангасан. Нийт 8 улсын 30 гаруй банк ашигладаг.

Блокчэйн сүлжээг ашиглан дансны хуулгаа баталгаажуулах боломжтой боллоо

Хувь хүн, байгууллага нь өмч хөрөнгө болон эзэмшиж буй банкны данстай холбоотой мэдээллээ өөрөө удирдах, мэдээллийн үнэн зөв, өөрчлөгдөөгүй байдлыг нотлох шаардлагатай тохиолдол их гардаг. Тиймээс Голомт банк 2022 онд харилцагчиддаа банкны салбарт анх удаа дижитал шилжилтийн гол технологиудын нэг болох блокчэйн технологийг ашиглан уг баталгаажуулалтыг түргэн шуурхай хийх боломжийг олгож байна.

Тус үйлчилгээг ашигласнаар харилцагчид дансны хуулгаа, зээлийн үлдэгдэлтэй эсэхийг нотолсон тамгатай тодорхойлолтоо заавал салбараар үйлчлүүлж авах шаардлагагүй, ердөө л “Интернэт банк”-аа ашиглан блокчэйн сүлжээнд бүртгүүлэн татаж авах боломжтой. Үүний дараа таны дансны хуулгыг шаардсан байгууллага нь “Notly” үйлчилгээний вэбсайт эсвэл аппликэйшнийг ашиглан үнэн зөвийг баталгаажуулахад л хангалттай.

Голомт банк, Худалдаа хөгжлийн банк хамтран АТМ-ын шимтгэлээ буурууллаа

Голомт банк болон Худалдаа хөгжлийн банк харилцагчийн үйлчилгээний нөхцөлийг сайжруулах зорилготой хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичгийн хүрээнд зарлагын гүйлгээний шимтгэлийг багасгаж, хоёр талын өөртөө үйлчлэх банкны төхөөрөмж /АТМ, СDM, CRM/ дээр бэлнээр зарлага гаргахад шимтгэл 500₮ байсныг 100₮ болгон бууруулж байна. Өөрөөр хэлбэл Голомт банкны картын харилцагч Худалдаа хөгжлийн банкны АТМ төхөөрөмжөөс эсвэл Худалдаа хөгжлийн банкны харилцагч Голомт банкны АТМ төхөөрөмжөөс бэлэн мөнгө авахад дээрх үнийн дүнгээр шимтгэл төлөх боломжтой боллоо.

Бид энэ удаагийн үйл явдлаар дамжуулан харилцагч төвтэй банкны үйлчилгээг өргөжүүлэхэд нээлттэй, уян хатан хамтын ажиллагааг хэрэгжүүлж, салбарын хөгжилд хамтран хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

2022 оны ололт, амжилт

2022 оны “Монгол Улсын Шилдэг Банк”-аар тодорлоо

Дэлхийн банк, санхүүгийн салбарт нэр хүндтэй “The Banker” сэтгүүлээс Голомт банкийг 2022 оны “Монгол Улсын Шилдэг Банк”-аар тодрууллаа. Ийнхүү Голомт банк тус шагналыг 8 дахь удаагаа хүртэж, сүүлийн хоёр жил дараалан шилдгээр өргөмжлөгдөөд байна.



2022 оны “Монгол Улсын Шилдэг Дижитал Банк”-аар шалгарлаа

Олон улсын банк, санхүүгийн салбарын шилдгийг тодорхойлогч “Global Finance” сэтгүүлээс Голомт банкийг 2022 оны “Монгол Улсын Шилдэг Дижитал Банк”-аар дахин шалгарууллаа. Голомт банкны хувьд тус шагналыг 8 дахь жилдээ хүртэж байгаа төдийгүй сүүлийн дөрвөн жил дараалан ийнхүү шилдгээр тодроод байна.

2022 оны “Онцлох ТоС байгууллага”-аар шалгарлаа

Тогтвортой санхүүжилтийн холбоо (ТоС)-ноос жил бүр ТоС хэрэгжилтээр манлайлсан байгууллагуудыг Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран шалгаруулдаг билээ. Энэ жилийн хувьд ТоС холбооны гишүүнчлэлийн цар хүрээ өргөжин тэлж, ББСБ-уудыг хамруулсан бөгөөд нийт 11 байгууллагаас Голомт банкийг 2022 оны “Онцлох ТоС байгууллага”-аар тодрууллаа.

Голомт банк байгуулагдсан цагаасаа байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг дэмжин ажиллаж ирсэн бөгөөд дэлхийн 300 гаруй банкны хамтаар НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилгад нэгдэж, Монгол Улсаа төлөөлөн “Хариуцлагатай банкны зарчмуд”-ыг үндэслэгч банк болсноор уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тогтвортой хөгжлийн зорилтуудыг 4 дэх жилдээ хэрэгжүүлж байгаа билээ.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Ажиллахад хамгийн таатай газар”-аар батламжиллаа

Голомт банк нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Great place to work institute”-ээс “Ажиллахад хамгийн таатай газар” батламжийг Монгол Улсын банк, санхүүгийн салбарт анхлан авлаа.



"Олон улсад нэр хүнд бүхий "Great place to work institute" нь 30 гаруй жилийн турш 5 тивийн 90 гаруй улсын 11 сая ажилтнаас жил бүр судалгаа авч, тухайн байгууллага нь ажиллахад хамгийн таатай газар эсэхийг үнэлж батламжилдаг юм. Уг судалгаагаар ажилтнууд байгууллагаа итгэлцэл, хүндлэл, шударга байдал, бахархал, нөхөрлөл гэсэн таван үзүүлэлтээр өндөр нууцлалтайгаар үнэлж, GPTW институт нь байгууллагаас хараат бус байдлаар үр дүнг гаргадаг.

Голомт банк ийнхүү дэлхийн шилдэг компаниудтай эн зэрэгцэн үнэлэгдэж, тэргүүн туршлагуудын жишгээс суралцаж, байгууллагын соёлоо бэхжүүлэн ажиллаж байна.

“ТОП-100” аж ахуйн нэгжийн шилдэг 5-д шалгарлаа

“ТОП 100 аж ахуйн нэгж”-д Голомт банк 19 дэх жилдээ шалгарч буй бөгөөд энэ удаа шилдэг 5-д эрэмбэлэгдэж, өмнөх жилээс 4 байраар урагшиллаа. 2021 онд цар тахлын сөрөг нөлөө үргэлжилж, улсын эдийн засаг, банк санхүүгийн салбарын нөхцөл байдал амаргүй байсан ч бид үүссэн нөхцөл байдалд дасан зохицож, шуурхай арга хэмжээ авч ажилласнаар улсдаа 137 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлэн төлж, ингэснээр сүүлийн гурван жилд нийт 360 гаруй тэрбум төгрөгийн татвар төлөн эдийн засагтаа дэмжлэг үзүүлсэн байна.



“The Best Customer Centric Company” шагнал хүртлээ

Голомт банк харилцагчдын эерэг туршлагыг бий болгож, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд үргэлж анхаарч, CX суурьтайгаар бүх дотоод үйл ажиллагаа, менежментээ сайжруулан өөрчилсөн. Мөн харилцагчдын санал хүсэлтийг хүлээн авч хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, хүлээлтийг давсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бүх сувгаар хүргэн ажилладаг учраас “The Future of Customer Experience Conference”-ийг зохион байгуулагчдын зүгээс бидэнд “The Best Customer Centric Company” шагнал хүртээснийг дуулгахад таатай байна.



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Голомт банк бүтээгдэхүүн үйлчилгээгээ ямагт сайжруулахын тулд харилцагч төвтэй байж тэдний дуу хоолойг үйл ажиллагаандаа тусган, үйлчилгээгээ илүү хялбар, хүртээмжтэй, үр өгөөжтэй байлгахад анхаарал хандуулан ажиллаж байна. Тийм ч учраас бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж зах зээлд эзлэх байр сууриа улам нэмэгдүүлсээр байна.

Тогтвортой Санхүүжилт

Голомт банк нь тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд ногоон зээлийн багцын хэмжээг өсгөх, гадны тогтвортой болон ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, байгаль орчин нийгмийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх мөн өөрийн үйл ажиллагааг байгаль орчин нийгэмд илүү ээлтэй байлгах зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтынхоо хүрээнд 2022 онд Тогтвортой, Ногоон бизнесийн зээл, Олон улсын EDGE стандартад суурилсан Ногоон амины орон сууцны зээл болон эко-автомашин зээлийн бүтээгдэхүүнүүдийг шинээр нэвтрүүллээ. Голомт Банк нь МУ-ын Ногоон Таксономийн дагуу ногоон зээлийн багцыг ангилан тайлагнадаг бөгөөд зээлийн багцын 57% нь ногоон барилга, 21% нь тогтвортой хөдөө аж ахуй, 21% нь тогтвортой ус, хаягдлын хэрэглээ салбаруудад тус тус олгогдсон бол бусад хувь нь карбон бага тээвэр, сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт салбаруудад олгогдсон байна.

Голомт Банк нь 2022 онд зээлийн Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээний дотоод журмыг шинэчилснээр байгаль орчин нийгмийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхгүй өндөр эрсдэлийг тодорхойлох, 400 гаруй эдийн засгийн дэд салбарын тусгайлсан суурь үнэлгээний загвар, ногоон зээлийн үнэлгээ хийх загварчлал зэрэг журмын олон сайжруулалтыг хийж БОН-ийн эрсдэлийн удирдлагад онцгой анхаарал хандуулж байна. 2022 онд Голомт Банк нийт 667 орчим бизнесийн зээл олгосны 71% хувьд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ бүрэн хийсэн байна.

Түүнчлэн БОН-ийн эрсдэлийн удирдлагын хүрээнд нүүрс хүчлийн хий их ялгаруулагч салбаруудыг тодорхойлон тэдгээрийн нүүрс хүчлийн хийг тооцоолох аргачлалыг нэвтрүүлж эдгээр салбаруудын зээл тус бүр дээр хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолдог боллоо. Улмаар харилцагчдынхаа үйл ажиллагааны ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, бууруулах арга замыг тодорхойлж хамтран ажиллах бүрэн боломжтой болж байна. Мөн Голомт Банк нь “Partnership for Carbon Accounting Financials” хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох олон улсын стандартын байгууллагад гишүүнээр элсэн энэхүү олон улсын аргачлалыг зээлийн үнэлгээндээ тусган ажиллаж байна.

ТоС Холбооны Үнэлгээ

“Монголын Тогтвортой санхүүгийн холбоо” нь 2016 оноос хойш нийт гишүүн банкны дунд ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээ хийж байгаа бөгөөд 2022 оны ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээг Монголбанк, Олон улсын Санхүүгийн корпорацитай хамтран хийж гүйцэтгэн Голомт Банк А+ үнэлгээ авч ТоС-ийн хэрэгжилтийн үр дүнг ахиуллаа.


НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр Санхүүгийн Санаачилга (UNEP FI)

НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчмуудын хэрэгжилтийн хүрээнд UNEP FI-аас гаргасан тусгай аргачлалын дагуу Голомт банк нийт зээлийн багцдаа “Impact analysis” буюу байгаль орчин уур амьсгалын нөлөөллийн шинжилгээ хийж гүйцэтгэсэн. Нийт зээлийн багцын хүрээнд impact analysis хийснээр байгаль орчин нийгмийн аль хэсэгт Голомт банкны зээлийн багц нөлөөлөл үзүүлж буйг тодорхойлж үр дүнд суурилан 2022 онд

зээлийн багцын уур амьсгалын эрсдэл, усны нөөцийн нөлөөллийг хэмжин суурь дата бүрдүүлэн ажилласан. Үүгээр дамжуулан зээлийн багцын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах тоон зорилт тавин ажиллаж байна.

Зээлийн үйлчилгээ

Голомт банк нь 2022 оны жилийн эцсийн байдлаар зээлийн зориулалт болон эргэн төлөгдөх эх үүсвэрт нийцсэн нийт 80 гаруй зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад санал болгон ажилласан бөгөөд нийт зээлийн 34 хувийг корпорэйт байгууллага, 26 хувийг жижиг дунд байгууллага, 21 хувийг орон сууцны зээл, 19 хувийг хэрэглээний зээл эзэлжээ. Зээлийн бүтээгдэхүүний сегмент бүрт тэнцвэртэй, тогтвортой өсөлтийн бодлогыг баримтлан ажиллаж байна.



Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

Голомт банк нь Монгол улсын хэмжээнд эдийн засгийг дэмжих, иргэдийн хуримтлалыг нэмэгдүүлж, хуримтлуулах зуршлыг дэмжих зорилгоор үндсэн 4 чиглэлийн хүрээнд хуримтлал үүсгэх, хүүхдийн, хөрөнгө оруулалтын, гэнэтийн хэрэгцээний зэрэг 15 төрлийн хадгаламжийн бүтээгдэхүүнийг иргэд болон байгууллагад санал болгон ажиллаж байна. 2022 оны байдлаар хамгийн өндөр буюу нийт хадгаламжийн 50 орчим хувийг хуримтлал үүсгэх зориулалт бүхий хадгаламж эзэлжээ.



Мөн харилцагчдын хуримтлалын болон харилцахын тогтмол хэрэглээг урамшуулах “Big loyalty”, “GenZ loyalty”, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан харилцагчдын хэрэгцээнд тохирсон “Social pay loves you”, “Si card”-н хөнгөлөлт урамшуулал зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээг 2022 оны турш санал болгон амжилттай хэрэгжүүллээ.

Гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээ

Голомт банк нь олон улсын 153 банк, санхүүгийн байгууллагуудтай шууд болон зорилтот зээл, худалдааны санхүүжилт, Экспортын Санхүүжилтийн Агентлагтай хамтарсан баталгаа, аккредитив, гадаад төлбөр тооцоо, валют арилжаа, зузаатгал болон бусад чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна. Үүнээс гадна харилцагч байгууллагуудын гадаад худалдааны бараа эргэлтийг сайжруулах, санхүүжилтийн өртгийг бууруулахад дэмжлэг үзүүлэн Солонгос, Япон, Хятад, Сингапур, Испани, Турк, Итали, Герман, Польш, Малайз, АНЭУ зэрэг орнуудтай хийж буй худалдан авалтыг аккредитив, гадаад баталгааны үйлчилгээгээр дамжуулан гүйцэтгэдэг. Тодруулбал, 2022 оны байдлаар Голомт банк нь Монгол Улсын хэмжээнд импортын аккредитивын 46 хувь, гадаад баталгааны тоогоор зах зээлийн 33 хувийг дангаар гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна.

Төлбөр тооцооны үйлчилгээ

2022 онд харилцагчийн мэдээллийн өндөр нууцлал бүхий хувийн мэдээллийг картад байршуулахгүй зайнаас унших NFC технологитой, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг EMV технологийн чипээр хамгаалсан онцлог дизайн бүхий Si дебит болон кредит картыг хэрэглээнд нэвтрүүлэн ажиллалаа.

Тайлант хугацааны байдлаар Голомт банк нь иргэдэд зориулсан нийт 8 төрлийн кредит, 9 төрлийн дебит карт, байгууллагад зориулсан хүсэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурласан хамтарсан ко-бренд картын бүтээгдэхүүнийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт карт эзэмшигчдийн тоо 524.6 мянгад хүрч, онлайн худалдааны гүйлгээ өмнөх оноос 29 хувиар өсөж зах зээлийн 48 хувийг эзэлсэн байна.

Гадаад төлбөр тооцоо

Голомт банк нь олон улсын нэр хүнд бүхий 29 арилжааны банкин дахь 50 орчим дансаар дамжуулан, 15 төрлийн валютаар гадаад төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж байгаа ба тайлант онд Шинэ Зеланд улсын ANZ Bank (ANZ NZ)-тай корреспондент бизнесийн харилцаагаа өргөжүүлж, олон улсын төлбөрийн системдээ “Шинэ зеаланд Доллар” (NZD) валютыг нэвтрүүллээ.

2022 оны байдлаар банкны системд хийгдсэн гадаад төлбөр тооцооны 26 хувийг, банкны системийн хэмжээний 36 хувийг дангаар бүрдүүлсэн байна.

Даатгалын зуучлалын үйлчилгээ

Голомт банк нь ипотека, хүнд болон тусгай зориулалтын машин механизм, тээврийн хэрэгсэл, аялал, гэнэтийн ослын болон хөрөнгийн даатгалын үйлчилгээ үзүүлдэг. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 172,338 харилцагчийг даатгалд хамруулж, 8.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг татан төвлөрүүлсэн байна. Харилцагчдын тоо 2022 онд 23 хувиар, нийт хураамжийн орлого 29.7 хувиар тус тус өсжээ.

Кастодиан банкны үйлчилгээ

Голомт банк нь дэлхийд тэргүүлэгч JP Morgan банкны Монгол дахь цорын ганц саб-кастодиан банк бөгөөд тус банкны жил бүрийн магадлан шинжилгээнд 5 дах жилдээ амжилттай хамрагдан, эерэг үр дүн хүлээн авлаа. МУ-ын Хөрөнгийн зах зээл дэх анхны

Хамтын Хаалттай Хөрөнгө Оруулалтын Сангуудад хөрөнгө хадгалах сангийн цогц үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд зах зээлд анхдагч болон сангуудын цэвэр хөрөнгийн үнэлгээг тооцоолон олон нийтэд мэдээлж байна. Түүнчлэн Сангийн нэгж эрхийн арилжааны аппликэйшнтэй Кастодиан банкны системийг амжилттай холбож зах зээлд нэвтрүүлэхэд хамтран ажиллалаа.

Голомт Кастодиан Банкны хамтын ажиллагаатай глобал кастодиан банкаар дамжуулан харилцагчдын гадаад зах зээлд арилжиж буй үнэт цаасны төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэж, хадгалалтын үйлчилгээг харилцагчдад зах зээлд өрсөлдөхүйц таатай нөхцөлөөр хүргэж байна.

Валютын арилжаа

Голомт банк нь Монгол Улсын банкны системийн нөлөө бүхий банк бөгөөд валют арилжааны зах зээл дээрх тэргүүлэгч байр сууриа амжилттай хадгалж байна. 2022 онд гадаад болон дотоод орчны тодорхой бус байдал, геополитикийн хурцадмал байдал, Хятадын засгийн газрын “Тэг-ковид” бодлого зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан дотоодын валютын зах зээлд валютын хомсдол үүсэж, ханшийн огцом сулралт бий болсон. Гэсэн хэдий ч харилцагчдынхаа валютын эрэлт, хэрэгцээг тогтмол хангаж, ханшийн эрсдэлийг бууруулахын тулд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг санал болгож ажиллалаа.

Голомт банк нь 2022 онд Шинэ Зеланд долларын валют арилжааг харилцагчдадаа санал болгож эхэлсэн ба өдөр тутамд 16 төрлийн валютаар арилжаа, төлбөр тооцоог хийж байна.

Хеджинг

Голомт банк 2019 оноос валют болон түүхий эдийн хеджингийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын томоохон нефть импортлогч болон алт олборлогч компаниудад тус бүтээгдэхүүнийг санал болгох замаар харилцагчдынхаа мөнгөн хөрөнгийг зах зээлийн гэнэтийн шокоос урьдчилан хамгаалж, эрсдэлийг удирдан ажиллалаа. Цаашид хеджингийн үйлчилгээг бүх төрлийн түүхий эд болон олон төрлийн валют дээр нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Алтны арилжаа

2022 онд Монголбанканд тушаасан нийт алтны хэмжээгээр Голомт банк нь алтны зах зээл дэх өөрийн тэргүүлэгч байр сууриа хадгалж чадлаа. Бид харилцагчдын хөрөнгө оруулалтын сонголтыг нэмэгдүүлэхээр “Биет бус алтны арилжаа”-г нэвтрүүлсэн бөгөөд харилцагчид хүссэн үедээ дансны алтыг өөрийн нэр дээр эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэн, шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн олон улсын зах зээл дээрх санхүүгийн үүсмэл бүтээгдэхүүнийг харилцагчдадаа санал болгохоор ажиллаж байна.



Бид хуримтлуулсан туршлага, олж авсан мэдлэг, бүтээсэн дэд бүтцээ харилцагчидтайгаа хуваалцах замаар шинэ үнэ цэн бүтээж, иргэдийн амьдрал, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулдаг нээлтэй банк байна.



САНХҮҮГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

2022 ТАЙЛАН

АУДИТЫН ДҮГНЭЛТ



Хураангуй санхүүгийн тайлангийн хараат бус аудиторын тайлан

Голомт Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Голомт Банк ХК ("Банк" гэх)-ийн хураангуй санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд хураангуй санхүүгийн тайлангуудын тодруулгад тусгаж тайлбарлагдсаны дагуу аудитлагдсан санхүүгийн тайлангуудтай тохирч байна.

Хураангуй санхүүгийн тайлангууд

Банкны хураангуй санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангуудад үндэслэн бэлтгэгдсэн дараах тайлангууд болон тодруулгаас бүрдсэн. Үүнд:

- 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хураангуй санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хураангуй орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан;
- санхүүгийн тайлангуудыг бэлтгэх үндэслэлийг тайлбарласан тодруулга.

Энэхүү хураангуй санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-аар шаардсан бүх тодруулгуудыг агуулаагүй. Иймд энэхүү хураангуй санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлт нь аудитлагдсан санхүүгийн тайлангууд болон аудиторын дүгнэлтийг орлох үндэслэл болохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлангууд болон бидний дүгнэлт

Бид 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар аудитлагдсан санхүүгийн тайланд аудитын гол асуудлыг багтаасан аудитын хязгаарлалтгүй дүгнэлтийг гаргасан.


Хураангуй санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Хураангуй санхүүгийн тайлангуудын тодруулгад тайлбарласны дагуу хураангуй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх нь удирдлагын хүлээх хариуцлага болно.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол Аудитын олон улсын стандарт 810 (Шинэчлэгдсэн) буюу "Хураангуй санхүүгийн тайланд дүгнэлт өгөх ажил"-ын дагуу шаардсан аудитын горимуудыг гүйцэтгэж, түүнд үндэслэсэн хураангуй санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлангуудтай тохирч байгаад дүгнэлт өгөх болно.

Гарын үсэг зурсан


 Даваагийн Баярмаа
 Гүйцэтгэх захирал
 ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр
Улаанбаатар хот, Монгол Улс



Шаукат Тапиа
 Удирдах Партнер
 ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК


Санхүүгийн байдлын тайлан


Голомт Банк ХК Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Хөрөнгө		
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	1,142,404,090	694,954,420
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	357,581,959	277,343,522
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	1,566,963,380	1,056,447,510
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	1,230,251,009	1,979,439,874
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	22,513,491	18,472,715
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,697,633,345	3,339,174,837
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	10,276,475	17,427,586
Бусад хөрөнгө	283,402,128	39,972,362
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	436,146,109	208,917,059
Биет бус хөрөнгө	20,948,388	17,848,672
Үндсэн хөрөнгө	151,367,641	150,019,342
Ашиглах эрхтэй хөрөнгө	15,192,622	13,001,148
Өмчлөх бусад хөрөнгө	43,191,321	106,953,168
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	6,687,575	74,084,536
Нийт хөрөнгө	8,984,559,533	7,994,056,751
Өр төлбөр		
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	52,394,763	16,782,536
Харилцагчдын харилцах, хадгаламж	5,743,297,867	5,463,543,390
Бусад зээлийн эх үүсвэр	1,916,312,092	1,509,446,027
Репо хэлцэл	211,347,644	221,912,121
Орлогын татварын өглөг	30,961,395	29,389,944
Хойшлогдсон татварын өр төлбөр	20,743,288	9,484,597
Түрээсийн өр төлбөр	16,290,486	14,001,667
Бусад өр төлбөр	131,306,235	70,834,446
Нийт өр төлбөр	8,122,653,770	7,335,394,728
Эзэмшигчдийн өмч		
Давуу эрхтэй хувьцаа	-	16,388,100
Хувь нийлүүлсэн хөрөнгө	202,164,327	168,638,148
Нэмэгдэж төлөгдсөн капитал	301,481,120	169,486,044
Хуримтлагдсан ашиг	283,420,821	242,436,053
Өмчийн бусад хэсэг	74,839,495	61,713,678
Нийт эзэмшигчдийн өмч	861,905,763	658,662,023
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	8,984,559,533	7,994,056,751

2023 оны 03 сарын 30-ны өдөр Банкны удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.


Ч.МӨНХЦЭЦЭГ
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга



К.НОРИХИКО
Гүйцэтгэх захирал


С.МӨНХТУЯА
Санхүүгийн Удирдлагын Газрын
Захирал

Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Голомт Банк ХК
Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянаан төгрөгөөр	2022	2021
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	576,384,931	526,486,180
Бусад адилтгах орлого	33,524,234	28,291,422
Хүүгийн зардал	(222,857,161)	(271,257,957)
Бусад адилтгах зардал	(1,481,221)	(1,560,592)
Хүүгийн цэвэр орлого	385,570,783	281,959,053
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	(45,969,488)	(35,770,454)
Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого	339,601,295	244,406,096
Хураамж, шимтгэлийн орлого	84,131,978	62,493,142
Хураамж, шимтгэлийн зардал	(39,961,185)	(21,714,228)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз	7,326,760	1,695,813
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн гэрээний өөрчлөлтөөс үүссэн олз	1,794,198	3,638,530
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн борлуулалтаас үүссэн гарз	(48,339)	(626)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз(гарз)	34,725,648	(21,818,582)
Үнэт металлын арилжаанаас үүссэн олз	7,815,364	4,785,518
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз(гарз)	(10,060,088)	153,074
Гадаад валютын арилжаанаас үүссэн олз	58,228,967	20,398,503
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх зээлийн бодит үнэ цэнийн гарз	(6,120,026)	(14,571,327)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн үнэ цэнийн гарз, бүртгэлээс хасагдахгүй	(1,688,544)	(848,111)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн алдагдлын сангийн буцаалт	4,181	(2,676)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал	(662,323)	(1,782,503)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	(3,584,406)	13,591
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз	(235,786)	(2,636,090)
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	(868,016)	(539,852)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн олзоос хасах гарз	5,413	(3,973,106)
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтын сангийн зардал болон эрсдэлийн сангийн зардал	(96,897,798)	(78,887,826)
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардал	(509,336)	1,958,933
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлтийн гарз	(3,372,606)	(7,426,258)
Ногдол ашгийн орлого	32,813	204,394
Үйл ажиллагааны бусад орлого	1,154,973	3,835,000
Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	(175,345,911)	(137,139,597)
Бусад гарз, цэвэр дүнгээр	(1,669,242)	(1,453,421)
Татварын өмнөх ашиг	193,797,984	52,570,894
Орлогын албан татварын зардал	(77,295,936)	(26,634,228)
Тайлант жилийн ашиг	116,502,048	25,936,666
Бусад дэлгэрэнгүй орлого(алдагдал):		
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд аншлагдах зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт		
- Тайлант жилийн гарз	(50,471,551)	2,680,637
- Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилагдсан олз(гарз)	48,339	626
Дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар	12,605,803	(670,316)
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд аншлагдахгүй зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз	(558,251)	1,153,870
Дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар	139,563	(288,468)
Бусад дэлгэрэнгүй орлого	(38,236,097)	2,876,349
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	78,265,951	28,813,015
Банкны эзэмшигчдэд хамаарах нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	163.80	35.92

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Голомт Банк ХХК
Өмчийн өөрчлөлтийн тайлан
2022 оны 12 сарын 31

Мяванд төгрөгөөр	Энгийн хувьцаа	Давуу эрхтэй хувьцаа	Халаасны хувьцааг давуу эрхтэй хувьцаа	Халаасны хувьцаа	Нэмэгдэж төлөгдсөн капитал	БДОБҮЦ-ээрх ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эзэмшигчдийн өмч
2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	42,240,037	25,778,900	(9,390,800)	(80,500)	291,843,805	(12,862,023)	7,495,543	75,680,019	210,853,485	631,558,466
Тайлант хугацааны ашиг	-	-	-	-	-	-	-	-	25,936,666	25,936,666
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	2,876,349	-	-	-	2,876,349
2021 оны нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	2,929,433	-	-	25,936,666	28,813,015
Хувьцааны нэрлэсэн үнийн өсөлт	126,720,111	-	-	(241,500)	(126,478,611)	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн БДОБҮЦ-ээрх өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	-	9,349,580	-	-	(9,349,580)	-
Зарласан болон төлөгдсөн ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-	(1,709,458)	(1,709,458)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-	(250,441)	-	250,441	-
МБ-ны журмын дагуу бусад нөөц рүү шилжүүлсэн нөөц	-	-	-	-	-	-	-	(20,575,349)	20,575,349	-
Бусад	-	-	-	-	4,120,850	-	-	-	(4,120,850)	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	168,960,148	25,778,900	(9,390,800)	(322,000)	169,486,044	(636,094)	7,245,102	55,104,670	242,436,053	658,662,023
Тайлант хугацааны ашиг	-	-	-	-	-	-	-	-	116,502,048	116,502,048
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	(38,236,097)	-	-	-	(38,236,097)
2022 оны нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	(38,236,097)	-	-	116,502,048	78,265,951
Шилээр гаргасан энгийн хувьцаа	33,526,179	-	-	-	131,788,974	-	-	-	-	165,315,153
Халаасны хувьцааны буцаан худалдан авалт	-	-	(16,388,100)	-	-	-	-	-	(14,271,600)	(30,659,700)
Эргэлтээс гаргасан хувьцаа	(322,000)	(25,778,900)	25,778,900	322,000	206,102	-	-	-	-	(206,102)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн оруулалтын дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	-	3,065,729	-	-	(3,065,729)	-
Зарласан болон төлөгдсөн ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-	(555,404)	(555,404)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-	(250,440)	-	250,440	-
МБ-ны журмын дагуу бусад нөөц рүү шилжүүлсэн нөөц	-	-	-	-	-	-	-	47,699,164	(47,699,164)	-
Хувьцаанд суурилсан төлбөр	-	-	-	-	-	-	-	847,461	-	847,461
Бусад	-	-	-	-	-	-	-	-	(9,969,721)	(9,969,721)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	202,164,327	-	-	-	301,481,120	(35,806,462)	6,994,662	103,651,295	283,420,822	861,905,763

Мөнгөн гүйлгээний тайлан

Голомт банк ХК
Мөнгөн гүйлгээний тайлан – 2022 оны 12 сарын 31

<i>Мянган төгрөгөөр</i>	2022	2021
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Татварын өмнөх ашиг	193,797,984	52,570,894
Мөнгөн бус орлого, зардлын тохируулгууд:		
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	45,969,488	35,770,454
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгөөс үүссэн (олз)/гарз	48,339	626
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн (олз)/гарз	(7,326,760)	(1,695,813)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн гэрээний өөрчлөлтөөс үүссэн олз	(1,794,198)	(3,638,530)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн (олз)/гарз	(34,725,648)	21,818,582
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз, бүртгэлээс хасагдахгүй	1,688,544	848,111
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх зээлийн гарз	6,120,026	14,571,327
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	3,584,406	(13,591)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт	662,323	1,782,503
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн алдагдлын сангийн зардал	(4,181)	2,676
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз	235,786	2,636,090
Үндсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны (олз)/гарз	1,669,242	1,453,421
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (олз)/гарз	10,060,088	(153,074)
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	868,016	539,852
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардлын буцаалт	509,336	(1,958,933)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний гарз	3,372,606	7,426,258
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн гарз	(5,413)	3,973,106
Элэгдлийн зардал	27,077,479	24,555,445
Хорогдуулалтын зардал	6,063,280	3,837,579
Данснаас хассан үндсэн хөрөнгө	66	18,397
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтаас үүссэн гарз болон үнэ цэнийн бууралтын сангийн зардал	96,897,798	78,887,826
Хүүгийн орлого	(609,909,165)	(554,777,602)
Хүүгийн зардал	224,338,382	272,818,549
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ	(30,802,176)	(38,725,847)
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийн цэвэр (өсөлт) / бууралт	(79,911,039)	(33,853,818)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт	(290,629,936)	95,873,906
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр (өсөлт) / бууралт	12,343,979	(2,188,600)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өмчийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр (өсөлт) / бууралт	(95,171)	1,029,277
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны цэвэр (өсөлт)	(567,177,200)	(514,728,118)
Бусад хөрөнгийн цэвэр бууралт	(14,297,782)	80,328,375
Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр (өсөлт)	85,278,199	(44,115,715)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн цэвэр бууралт	(44,592,847)	76,700,121
Банкуудын байршуулсан хөрөнгийн цэвэр (өсөлт) / бууралт	31,075,728	2,102,465
Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр (өсөлт) / бууралт	284,574,136	256,942,420
Бусад өр төлбөрийн цэвэр (өсөлт)	60,809,914	(28,003,168)
Татвар болон хүүгийн өмнөх үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(553,424,195)	(148,638,702)
Төлсөн орлогын албан татвар	(51,720,490)	(1,075,077)
Хүлээн авсан хүү	616,840,938	557,033,125
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх хөрөнгө оруулалтаас хүлээн авсан хүүгийн орлого	4,715,191	8,317,135
Төлсөн хүү	(225,243,451)	(382,483,341)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(208,832,007)	33,153,141

Голомт банк ХК
Мөнгөн гүйлгээний тайлан – 2022 оны 12 сарын 31

<i>Мянган төгрөгөөр</i>	2022	2021
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	(112,280,200)	(93,473,456)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өмчийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	138,979	12,837,742
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	7,516,430	18,648,928
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	(21,121,361)	(25,795,226)
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	508,280	704,525
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	(9,162,995)	(4,931,907)
Эргэлтийн бус хөрөнгийн урьдчилгаа	(230,000,000)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(364,400,867)	(92,009,394)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
РЕПО хэлцлээс орж ирсэн орлого	424,211,523	562,558,030
РЕПО хэлцлийн эргэн төлөлт	(447,033,190)	(367,560,485)
Бусад зээлийн эх үүсвэрээс орж ирсэн орлого	1,201,130,206	1,205,497,008
Бусад зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	(970,908,033)	(854,325,119)
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт	(5,758,791)	(5,205,254)
Шинээр гаргасан энгийн хувьцаа	165,315,153	-
Энгийн хувьцааны буцаан худалдан авалт	(30,659,700)	-
Төлсөн ногдол ашиг	(555,404)	(1,709,458)
Other disbursement	(6,600,000)	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	329,141,762	539,254,722
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	84,779,713	7,540,251
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	(159,311,400)	487,938,720
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,434,725,888	1,946,787,169
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,275,414,488	2,434,725,888

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Голомт банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж, салбартаа сайн жишиг тогтоосоор байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Байвал зохих	Голомт банк
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа*	>9%+4% нөөц интервал	17.91%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа*	>12%	17.91%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	36.29%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<+-15%	8.00%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<+-30%	10.76%

*2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэв.

Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлтүүд

Монголбанкны зохистой харьцаанаас гадна Голомт банк нь дотооддоо Базелын хорооноос боловсруулсан хөрвөх чадварын харьцаанууд болох LCR, NSFR-г тогтмол тооцоолон хянадаг. LCR буюу Liquidity Coverage Ratio нь банканд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхэд бэлэн мөнгөний хэрэгцээ доод тал нь хуанлийн 30 хоног байгаа эсэхийг илэрхийлэх харьцаа үзүүлэлт бөгөөд банк тус харьцааг 2022 онд тогтоосон лимитээс дээгүүр буюу 100%-аас дээш барьж ажилласан нь богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлээ зохистой түвшинд хангаж ажилласан болохыг илэрхийлж байна. Харин NSFR буюу Net stable funding ratio нь банкны урт хугацааны активын санхүүжилтийг хангах урт хугацааны тогтвортой пассивын хүрэлцээтэй байдлыг илэрхийлэх харьцаа үзүүлэлт ба тус харьцааг мөн 100%-аас дээш хангаж ажилласан нь банкны урт хугацааны хөрвөх чадварын эрсдэл нь зохистой түвшинд байгааг илтгэж байна.

	2022	Лимит
Liquidity ratio	36.29%	≥30%
LCR	185.2%	≥100%
NSFR	126.5%	≥100%

Харилцагчийн анхны шаардлагаар төлбөр гүйцэтгэх банкны чадварыг хангах, банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг Монгол банкнаас 25% гэж тогтоосон байдаг. Голомт банкны хувьд дотооддоо Актив, пассивын бодлогын хүрээнд 2022 онд тус харьцааг 30%-аас дээш хангаж ажиллах, төгрөг болон валютын ТТГЧ харьцааг тус бүр 22%-аас дээш хангаж ажиллахаар тогтоосон бөгөөд эдгээр харьцаануудыг 2022 оны турш хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ

Харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг хангахын тулд банк нь баталгаа, батлан даалтуудыг гарган ажилладаг. Эдгээр нь банкны санхүүгийн тайлангуудад тусгагддаггүй боловч санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгддэг онцлогтой. 2022 оны байдлаар банкны зээлтэй холбоотой гарсан баталгаа батлан даалтын хэмжээг танилцуулж байна.

Мянган төгрөгөөр	2022
Олгосон санхүүгийн баталгаа	66,863,233
Олгосон гүйцэтгэлийн баталгаа	355,360,186
Аккредитив	244,371,440
Ашиглаагүй зээлийн шугам	284,861,192
Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг	951,456,051

*2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэв.

Банкны нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив болон бусад үүрэг

2022 оны байдлаар Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан

Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)	Активын хэлбэр	Үлдэгдэл дүн (сая төгрөг)	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5%-иас хэтрэхгүй)			
Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, зээлийн шугам, баталгаа батлан даалт	31,759	3.87%
Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл, зээлийн шугам, баталгаа батлан даалт	3,185	0.39%
Банкны бусад холбогдох этгээд	Зээл, зээлийн шугам	15,344	1.87%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20%-иас хэтрэхгүй)			
Банкны хувьцаа эзэмшигчид	Авлага, зээл, зээлийн шугам, баталгаа батлан даалт	42,248	5.15%
Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл, зээлийн шугам, баталгаа батлан даалт	9,411	1.15%
Банкны бусад холбогдох этгээд	Зээл, зээлийн шугам, баталгаа, батлан даалт, авлага, хувьцаа	19,342	2.36%



ЗАХ ЗЭЭЛИЙН
ЭРСДЭЛИЙН
МЭДЭЭЛЭЛ

2022 ТАЙЛАН

2022 оны хувьд олон улс хоорондын мөргөлдөөн, дайны нөхцөл байдал холбоотой нийлүүлэлтийн болоод эрчим хүчний хямрал, төв банкнуудын инфляцтай хийх дайн, мөнгөний хатуу бодлого зонхилсон, БНХАУ-ын ковидын эсрэг бодлого зэрэг томоохон сорилт, бэрхшээлүүдийг дагуулсан жил байлаа. Эдийн засгийн голлох улсуудын тогтворгүй нөхцөл байдалд банк нь харилцагч болоод бизнесийн орчинд нөлөөлж болох эрсдэлийг олон улсын аргачлалын дагуу хянаж, хариу арга хэмжээг зохицуулагч байгууллагын бодлогын хүрээнд мөрдлөг болгон хамтран ажиллалаа.

Голомт банк нь эрсдэлийн засаглалын, “Гурван шугамын загвар”, эрсдэл даах чадвар, стресс тестийн үр дүнд суурилсан эрсдэл даах чадварын нөөц интервал бүрдүүлэлт, эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, гэрлэн дохионы аргачлал зэрэг Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хамаарах үндсэн бүрэлдэхүүнүүдийг улам сайжруулан дотооддоо мөрдлөг болгон ажиллаж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүдийн үндсэн зорилго нь Голомт банкны санхүүгийн болон санхүүгийн бус урт хугацааны тогтвортой байдлыг бэхжүүлэх, эрсдэлийн зохистой засаглалыг төлөвшүүлэхэд чиглэдэг бөгөөд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа үүнийг үндсэн эх сурвалж, удирдлага болгон ашигладаг. “Гурван шугамын аргачлал”-д нийцтэй байдлыг тодорхойлж олон улсын жишгийн дагуу баталж, мөрдөж ажилладаг. Үүнд:

- Банкны бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд “Нэгдүгээр шугам”-д хамаарна.
- “Нэгдүгээр шугам”-д хамаарах нэгжүүдийн эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд “Хоёрдугаар шугам”-д хамаарна.
- Хараат бус дотоод аудитын чиг үүрэгтэй нэгжүүд “Гуравдугаар шугам”-д хамаарна.

Банк эрсдэлийн таксономид дурдсан эрсдэлүүдийн материаллаг байдалд үндэслэн гол эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрт хязгаарлалт тогтоож ажилласан. Энэхүү хязгаарлалт нь банкны “Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл”-д тусгагдаж жил бүр шинэчлэгдэн батлагддаг.

Түүнчлэн, Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP)-ыг банк дотооддоо тооцож, нэгтгэсэн стресс тестэд ашиглах замаар холбогдох хороонд танилцуулан өөрийн хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Стратеги үнэлгээ – Зах зээлийн нөхцөл байдалд өөрчлөлт гарах, эсвэл өөрчлөлт гарахаар хүлээгдэж буй нөхцөлд банкны ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгөд эрсдэлийн аппетитад хэрхэн нөлөөлөхийг тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж дүгнэлт хийж дахин үнэлж стресс тестийн гол төсөөллүүд дээр үндэслэдэг ба үр дүнг дараа жилийн стратеги, бизнесийн төлөвлөгөөг боловсруулалт тусгаж ажилладаг. Энэхүү хариу арга хэмжээний зохицуулагч байгууллагын бодлого, зохистой хэмжээний хүрээнд боловсруулагддаг.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Тайлант хугацаанд санхүүгийн зах зээлд валютын ханш, хувьцаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, зэрэг эрсдэл тулгарсан ч банк зах зээлийн эрсдэлийн удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлснээр болзошгүй алдагдлаас хамгаалж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажилласан.

2022 онд Голомт банк нээлттэй гадаад валютын позицуудын хувьд Монгол банкнаас тогтоодог шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажиллалаа. Цар тахлын дараах эдийн засгийн нөлөөлөл болоод бодлогын өөрчлөлтөд банкны санхүүгийн болоод санхүүгийн бус үйл ажиллагааг бэлтгэж зохих дотоод хязгаар үзүүлэлтийг шинэчлэн баталж ажиллав. Түүнчлэн Актив Пассивын Хорооноос батлагдсан лимитийн хүрээнд валютын ханшийн эрсдэлээс учирч болзошгүй алдагдлыг “Value at Risk” аргачлалаар тооцож өдөр бүр хяналт тавьдаг бөгөөд харилцагч тал болон улс орны эрсдэлийг зээлжих зэрэглэл болон санхүүгийн харьцаа үзүүлэлтэд үндэслэн харилцагч бүрээр лимитийг тодорхойлж ажиллав. Мөн банк нь Монгол банкны мөнгөний хэрэгслийн хүрээнд урт хугацаат своп хэлцлийг байгуулж үүсмэл хэрэгслийн үнэ цэнийг Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт IFRS 9-н дагуу тайлагнаж ажиллав.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Тайлант хугацаанд банкны бизнес төлөвлөгөөнд тусгасны дагуу богино болон урт хугацаанд өндөр хөрвөх чадвар бүхий позицыг барих бодлогыг амжилттай хэрэгжүүллээ. Банкны хөрвөх чадвар 2022 оны турш Монголбанкнаас тогтоосон шаардлага болон банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдлийн хүрээнд хангалттай түвшинд ажиллалаа.

Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос тогтоосон стандартын дагуу банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа (LCR), дунд урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг (NSFR) тогтмол ашиглан, хангаж ажиллалаа. Түүнчлэн, учирч болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийг үнэлж, стресс тестийг тогтмол гүйцэтгэн, үр дүнг шийдвэр гаргалтад ашиглан удирдаж байна. 2020 онд бид банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан стандартын дагуу банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ILAAP)-ыг нэвтрүүлж үүний хүрээнд цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг тооцож, түүнд үндэслэн банкны эрсдэл даах чадварыг тодорхойлж байна.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг улам сайжруулах, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор дотоод бодлого, журам, аргачлал, хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, мөрдөн ажиллалаа.



ТАТАН
ТӨВЛӨРҮҮЛСЭН
ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТЫН
ТАЙЛАН

2022 ТАЙЛАН

Банк хувьцаагаа олон нийтэд санал болгох анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд авч, Greenshoe хэрэгжүүлсэн дүнгээр нийт 118,815,152,890 төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс СТОУС болон ААНОА-ын дагуу үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлыг хасагдуулж, нийт 116,712,124,684 төгрөгөөр банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Өөрийн хөрөнгийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	6/30/2022	12/31/2022
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	625,445	854,064
2	Өөрийн хөрөнгө (Ө.Х)	641,833	854,064
3	Эрсдэлээр жигнэсэн актив	4,458,178	4,768,641
№	Үзүүлэлт	6/30/2022	12/31/2022
1	I зэрэглэлийн Ө.Х-ийн хүрэлцээ (>9.0%)	14.03%	17.91%
2	Нийт Ө.Х-ийн хүрэлцээ (>12.0%)	14.40%	17.91%

*2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэв.

Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр дээрх өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлт ойролцоогоор 2.5 хувиар сайжирч эрсдэлээр жигнэсэн актив буюу зээлийн багцын хэмжээг өсгөх боломж бүрдсэн.

Тайлан боловсруулах өдрийн байдлаар банк олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу зээлийн олголт хийсэн байна.



НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 ТАЙЛАН

"Голомт банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2-р сарын 15-ны өдрийн хурлаар 2022 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 50 төгрөг тооцон ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн билээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоож, ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд зохицуулагч байгууллагын зөвшөөрөл ирснээс хойш 60 хоногийн дотор хуваарилахаар шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн шийдвэр гаргасан огноо	2023.02.15
Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр	2023.04.04 /Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр/
Нэгж хувьцаанд олгох ногдол ашиг	50 төгрөг
Нийт олгох ногдол ашгийн хэмжээ	40,432,865,300₮ төгрөг
Ногдол ашиг тараалтын харьцаа %	40.4%
Ногдол ашгийн өгөөж % /2023.02.15 өдрийн хаалтын ханш/	4.4%



ЦАЛИН
УРАМШУУЛЛЫН
МЭДЭЭЛЭЛ

2022
ТАЙЛАН

Голомт банкны нийт цалин урамшууллын мэдээлэл 2022 оны байдлаар дараах байдалтай байна.

/Мянган төгрөг/	2022 он
Цалин хөлс, урамшуулал	55,360,029
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	6,780,120
Ажилчдын тэтгэмж	658,404
Тэтгэвэрийн сан	260,466
Ажилчдын сургалт	466,532

**2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэв.*



НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГА

2022 ТАЙЛАН

“Өв соёлын голомт” ТӨСӨЛ

Голомт банк “Өв соёлын голомт” түүх археологийн төслийг санаачилж, ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж эхэллээ. Төслийн эхний ажил болох Хэрэйдийн Ван ханы ордон буюу Түргэний балгас-Туулын “Хар Түнэ Орд” дурсгалт газарт археологийн малтлага, судалгааны ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Энэхүү түүхийн дурсгалт газарт 2006 оноос хойш судалгаа шинжилгээний ямар нэгэн ажил хийгдээгүй урт хугацаанд зогсонги байдалтай байсан ч сэргээн судлахаар болсон түүхийн 2-3 цаг үеийг хамаарах өндөр ач холбогдол бүхий дурсгалт газар юм. Археологийн хүрээлэн урьд өмнө санхүүжилтээс шалтгаалан малтлага, судалгааны ажлыг дийлэнхдээ гадны байгууллагуудтай хамтран хийдэг байсан бол Голомт банк энэ салбарт хөрөнгө оруулалт хийсэн анхны дотоодын хувийн хэвшлийн байгууллага болсноороо онцлогтой. Тус хамтын ажиллагаа нь зөвхөн энэ төслөөр хязгаарлагдахгүй бөгөөд цаашид Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг арга зүйн дагуу шинжилж, гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслүүд дээр хамтарч, урт хугацаанд дэмжин ажиллана.



“Зүрх мартахгүй” Төсөл

Голомт банкны дэргэдэх “Алтантүлхүүр” хүүхдийн сан “Зүрх мартахгүй” төслийг 3 дахь жилдээ дэмжин ажиллалаа. Төслийн багийнхан 2022 онд Монгол, Киргизстан, Тува гурван улсын олон мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулан, мэс засал хийж амьдрал бэлэглэсэн. Голомт банкны зүгээс тус төсөлд жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна шаардлагатай бусад зүйлсээр дэмжин ажиллаж байна. Бидний хамтын ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар нийт 18 мянган хүүхдийг үзлэг, оношилогоонд хамруулж, 600 гаруй хүүхдэд мэс заслыг амжилттай хийгээд байна. Эх орныхоо өнцөг булан бүрд очиж төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдэд дэлхийн жишиг үнээс 5-10 дахин бага зардлаар 99 хувийн үр дүнтэй мэс засал хийдэг энэхүү төслийг НҮБ-аас эхлэн олон улсад сонирхон анхаарлаа хандуулж эхэлсэн. Эдгээрээс гадна Англи, АНУ, Бельги зэрэг орнуудаас зүрхний төрөлхийн гажигтай хүүхдүүд ирж мэс засалд амжилттай орсон тохиолдлууд ч бий. Төслийн багийнхан анх жилд 44 хүүхдэд мэс засал хийх төлөвлөгөөтэй байсан ч хамтын ажиллагааны үр дүнд санхүүгийн болон бусад асуудлууд тодорхой хэмжээнд шийдэгдсэнээр нэг жилд хийх мэс заслын тоог 350-360 болгон нэмэгдүүллээ.



Оюутны тэтгэлэгт хөтөлбөр


Боловсролыг дэмжигч Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг “100 оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-өө 18 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. 2022 оны байдлаар энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нийт 50 гаруй их, дээд сургуулийн 15 салбарын нийт 1,600 оюутанд 1 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулаад байна. Голомт банкны нэрэмжит тэтгэлэгт оюутан болсноор зөвхөн мөнгөн тэтгэлэг аваад зогсохгүй банкны судлаач оюутнаар ажиллах, мөн “C student club”-ийн гишүүн болж сурч хөгжих, нийгэмдээ чиглэсэн ажлууд хийх зэрэг хувь хүнийхээ хувьд өөрийгөө хөгжүүлэх, сорих боломжууд нээгддэг бөгөөд тэтгэлгийг мэргэжил харгалзахгүй олгодгоороо давуу талтай. Тус хөтөлбөрт хамрагдсан оюутнууд их дээд сургуулиа төгсөөд Голомт банканд ажиллах тогтвортой ажлын байраар хангагдах боломжтой төдийгүй ажлын гараагаа банкнаас эхэлж, удирдах албан тушаалд амжилттай ажиллаж байгаа олон жишээ бий. Тэтгэлэгт оюутнууд Голомт банкны судлаач оюутнаар ажиллах боломж давхар нээгддэг иймд оюутнууд онолын түвшинд олж авсан мэдлэгээ практик дээр хэрэгжүүлэн мэргэжлийн хамт олон дунд судалгааны ажил хийж өөрийгөө хөгжүүлэх бүрэн боломжтой.



Морин хуурын чуулга

Голомт банк үндэсний язгуур урлаг, түүх соёлыг дэлхий дахинд таниулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад хувь нэмрээ оруулан Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны түнш байгууллагаар 12 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Морин хуурын чуулга нь 2022 онд 30 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд хоёр байгууллагын хамтын ажиллагааны хугацаанд гадаад болон дотооддоо үндэсний урлагийг сурталчлан таниулж нийт 35 гаруй томоохон тоглолт хийсэн.





www.golombank.com